



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ХИШИГ-ӨНДӨР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: БУА-2023/130/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Баталгаат тооцоолол аудит ХХК
Захирал: М.Буянбулган
Утас: 77153069 Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт	14
5.2 Албан шаардлага	14
5.3 Зөвлөмж	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЭМГ	Эрүүл мэндийн газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн тоолов 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймэг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.04.24 № 133

танил _____ ны № _____ т

ХИШИГ-ӨНДӨР СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ч.ТЭШИГМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Ковид-19 өвчлөл 1, 2, 8 дугаар сард гарсан. Эрт илрүүлэг үзлэг зохион байгуулсан. Хуучин эмнэлэгт их засвар хийгдэж, шинээр УАЗ 31519 маркийн 44,990.0 мянган төгрөгийн 1 машин хандиваар авсан байна.

Аудитын гол асуудал

Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төв нь 2022 онд аймгийн Эрүүл мэндийн газар болон Засаг даргатай Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын

D:\uchigraeg\2023\4\001

006020137

хүрээнд 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан. Эрүүл мэндийн дарга 95.0, сумын Засаг дарга 96.2 хувийн биелэлтэйгээр дүгнэгдсэн.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 713,259.3 мянган, орон нутгийн төсвөөс 44,514.0 мянган, нэмэлтээр 190,279.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан. 2021 онд төсвийн санхүүжилтийн дутуу 130,609.8 мянган төгрөгийн авлагатай байсан.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

0:bd1ghnreg/002344tot

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>274,009,872.52</u>	<u>397,388,437.64</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	12,731,243.94	209,949,965.52
31211	Төрийн сангийн харилцах	5,666,677.94	209,949,965.52
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	7,064,566.00	0.00
33	АВЛАГА	131,184,009.48	191,460.59
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	574,209.48	191,460.59
33300	Татаас, санхүүжилтийн авлага	130,609,800.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	130,094,619.10	187,247,011.53
351	Түүхий эд материал	46,030,092.90	74,854,648.46
35130	Эм боох материал	46,030,092.90	74,854,648.46
354	Хангамжийн материал	84,064,526.20	112,392,363.07
35410	Бичиг хэргийн материал	3,176,650.00	2,193,550.00
35420	Аж ахуйн материал	70,780,812.20	105,913,445.07
35430	Сэлбэг хэрэгсэл	3,196,750.00	3,068,350.00
35440	Түлш, шатах тослох материал	3,255,512.00	311,680.00
35460	Хүнсний материал	3,654,802.00	905,338.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>722,224,314.33</u>	<u>805,070,360.48</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	722,224,314.33	805,070,360.48
392	Биет хөрөнгө	703,873,439.33	787,056,985.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,392,983,519.51	1,392,971,976.89
39202	Хуримтлагдсан элэгдэл	(854,567,891.31)	(878,633,278.17)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,388,000.00	106,362,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(40,559,545.92)	(50,357,068.59)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	163,813,980.46	264,098,330.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,106,701.10)	(81,089,726.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,253,700.00	42,083,000.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,055,622.31)	(13,466,249.88)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,720,000.00	12,720,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,996,000.00)	(7,632,000.00)
393	Биет бус хөрөнгө	18,350,875.00	18,013,375.00
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(253,125.00)	(590,625.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	17,254,000.00	17,254,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>996,234,186.85</u>	<u>1,202,458,798.12</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>522,500.61</u>	<u>0.00</u>
41361	Байгууллагад төлөх өглөг	522,500.61	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>995,711,686.24</u>	<u>1,202,458,798.12</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	995,711,686.24	1,202,458,798.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	413,976,292.00	413,976,292.00
51101	Өмч: - төрийн	413,976,292.00	413,976,292.00
512	Хуримтлагдсан үр дүн	128,681,247.02	335,428,358.90
51210	Өмнөх үеийн үр дүн	128,681,247.02	128,681,247.02

51220	Тайлант үеийн үр дүн	0.00	206,747,111.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	453,054,147.22	453,054,147.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>996,234,186.85</u>	<u>1,202,458,798.12</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,407,507,448.72	1,022,835,842.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	292,983,528.72	205,393,294.99
120	Нийтлэг татварын бус орлого	292,983,528.72	205,393,294.99
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	292,983,528.72	205,393,294.99
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,114,523,920.00	817,442,548.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	579,532,800.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	471,555,930.00	59,669,248.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,340,000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	57,960,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	465,748,930.00	1,709,248.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,467,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,631,600.00	44,514,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,631,600.00	44,514,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,803,590.00	713,259,300.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,803,590.00	713,259,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,167,132,471.99	816,088,731.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,167,132,471.99	816,088,731.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,110,261,166.99	796,546,447.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	517,164,083.48	435,444,987.31
210101	Үндсэн цалин	256,783,509.08	277,268,141.81
210102	Нэмэгдэл	218,976,214.88	117,551,745.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,100,999.19	5,257,000.00
210104	Урамшуулал	35,303,360.33	35,368,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,430,789.00	53,719,696.90
210201	Тэтгэврийн даатгал	39,922,329.22	37,388,285.04
210202	Тэтгэмжийн даатгал	7,781,909.24	4,347,502.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,329,825.78	3,387,093.17
210204	Ажилгүйдлийн даатгал	1,033,034.90	775,466.51
210205	Эрүүл мэндийн даатгал	8,363,689.86	7,821,350.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,868,829.00	44,502,365.94
210301	Гэрэл, цахилгаан	6,348,354.00	5,199,956.94
210302	Түлш, халаалт	36,913,076.00	37,311,110.00
210303	Цэвэр, бохир ус	3,607,399.00	1,991,299.00

2104	Хангамж, бараа материалын зардал	72,154,505.00	60,613,359.10
210401	Бичиг хэрэг	2,168,800.00	3,822,700.00
210402	Тээвэр, шатахуун	14,031,598.00	21,473,195.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,680,000.00	3,315,572.90
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	528,900.00	1,953,955.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	53,745,207.00	2,984,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	27,063,936.00
2105	Нормативт зардал	337,156,303.69	107,508,802.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	302,710,834.70	96,623,888.90
210502	Хоол, хүнс	20,354,252.99	10,884,914.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,091,216.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,683,000.00	5,639,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	866,000.00	0.00
210604	Урсгал засвар	5,817,000.00	5,639,850.00
2107	Томилолт, зочны зардал	1,321,330.00	1,010,000.00
210702	Дотоод албан томилолт	1,321,330.00	1,010,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,429,630.00	894,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	133,600.00	413,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	668,900.00	158,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,000.00	68,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	67,000.00	95,200.00
210807	Газрын төлбөр	160,000.00	159,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	352,130.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,052,696.82	87,212,884.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,119,100.00	3,955,280.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,933,596.82	83,257,604.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,871,305.00	19,542,284.06
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	56,200,000.00	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	670,435.00	19,530,650.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	11,634.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	11,634.06
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	870.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	870.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	240,374,976.73	206,747,111.88
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	240,374,976.73	206,747,111.88

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	984,358,204.00	948,052,348.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	444,084.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	444,084.00	0.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	983,914,120.00	948,052,348.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	579,532,800.00	0.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	579,532,800.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	340,946,130.00	190,279,048.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,340,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	335,139,130.00	1,709,248.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,467,000.00	188,569,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,631,600.00	44,514,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,631,600.00	44,514,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,803,590.00	713,259,300.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,803,590.00	713,259,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	930,216,360.06	681,540,796.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	930,216,360.06	681,540,796.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	873,345,055.06	661,998,512.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	518,182,376.96	435,497,484.31
210101	Үндсэн цалин	257,801,802.56	277,320,638.81
210102	Нэмэгдэл	218,976,214.88	117,551,745.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,100,999.19	5,257,000.00
210104	Урамшуулал	35,303,360.33	35,368,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,430,789.00	53,284,451.01
210201	Тэтгэврийн даатгал	39,922,329.22	36,953,039.15
210202	Тэтгэмжийн даатгал	7,781,909.24	4,347,502.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,329,825.78	3,387,093.17
210204	Ажилгүйдлийн даатгал	1,033,034.90	775,466.51
210205	Эрүүл мэндийн даатгал	8,363,689.86	7,821,350.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,562,929.00	44,502,365.94
210301	Гэрэл, цахилгаан	6,348,354.00	5,199,956.94
210302	Түлш, халаалт	34,607,176.00	37,311,110.00
210303	Цэвэр, бохир ус	3,607,399.00	1,991,299.00
2104	Хангамж, бараа материалын зардал	85,133,650.00	46,704,526.10
210401	Бичиг хэрэг	4,807,400.00	1,989,500.00
210402	Тээвэр, шатахуун	14,427,120.00	18,529,363.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,680,000.00	3,315,572.90
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,993,980.00	1,989,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	61,225,150.00	20,880,890.00
2105	Нормативт зардал	146,177,190.10	64,264,840.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	119,038,690.10	53,600,390.00
210502	Хоол, хүнс	22,461,200.00	7,964,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,677,300.00	2,700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,340,190.00	10,717,165.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,540,190.00	480,000.00
210604	Урсгал засвар	7,800,000.00	10,237,165.00
2107	Томилолт, зочны зардал	1,321,330.00	1,010,000.00
210702	Дотоод албан томилолт	1,321,330.00	1,010,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,121,400.00	1,284,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	133,600.00	413,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	712,800.00	158,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,000.00	68,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	67,000.00	95,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	389,700.00
210807	Газрын төлбөр	160,000.00	159,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,075,200.00	4,733,480.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,075,200.00	4,733,480.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,871,305.00	19,542,284.06
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	56,200,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	670,435.00	19,530,650.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	11,634.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	11,634.06
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	870.00	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	870.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>54,141,843.94</u>	<u>266,511,551.58</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	41,410,600.00	69,292,830.00
222001	Тоног төхөөрөмж	40,060,600.00	69,292,830.00
223001	Бусад хөрөнгө	1,350,000.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(41,410,600.00)</u>	<u>(69,292,830.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	12,731,243.94	197,218,721.58
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	12,731,243.94
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,731,243.94	209,949,965.52

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	413,976,292.00	453,054,147.22	128,681,247.02	995,711,686.24
D02	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	413,976,292.00	453,054,147.22	128,681,247.02	995,711,686.24
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	413,976,292.00	453,054,147.22	128,681,247.02	995,711,686.24
D04	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	206,747,111.88	206,747,111.88
D05	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	413,976,292.00	453,054,147.22	335,428,358.90	1,202,458,798.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Тайлант оны	Хувь
--	----------	-------------	------

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	925,628,300.00	750,833,626.42	81.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	925,628,300.00	681,540,796.42	73.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	905,628,300.00	661,998,512.36	73.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	603,584,800.00	435,497,484.31	72.1
210101	Үндсэн цалин	339,749,300.00	277,320,638.81	81.6
210102	Нэмэгдэл	219,660,500.00	117,551,745.50	53.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,799,900.00	5,257,000.00	59.7
210104	Урамшуулал	35,375,100.00	35,368,100.00	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,448,200.00	53,284,451.01	70.6
210201	Тэтгэврийн даатгал	51,304,700.00	36,953,039.15	72.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,035,900.00	4,347,502.15	72.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,828,600.00	3,387,093.17	70.1
210204	Ажилгүйдлийн даатгал	1,207,300.00	775,466.51	64.2
210205	Эрүүл мэндийн даатгал	12,071,700.00	7,821,350.03	64.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	44,502,365.94	0.0
210301	Гэрэл, цахилгаан	0.00	5,199,956.94	0.0
210302	Түлш, халаалт	0.00	37,311,110.00	0.0
210303	Цэвэр, бохир ус	0.00	1,991,299.00	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	80,355,100.00	46,704,526.10	58.1
210401	Бичиг хэрэг	2,004,000.00	1,989,500.00	99.3
210402	Тээвэр, шатахуун	17,542,100.00	18,529,363.20	105.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,600,400.00	3,315,572.90	207.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,611,200.00	1,989,200.00	76.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	56,597,400.00	20,880,890.00	36.9
2105	Нормативт зардал	57,967,000.00	64,264,840.00	110.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,167,000.00	53,600,390.00	152.4
210502	Хоол, хүнс	20,100,000.00	7,964,450.00	39.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,700,000.00	2,700,000.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	73,625,500.00	10,717,165.00	14.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	58,319,300.00	480,000.00	0.8
210604	Урсгал засвар	15,306,200.00	10,237,165.00	66.9
2107	Томилолт, зочны зардал	1,968,800.00	1,010,000.00	51.3
210702	Дотоод албан томилолт	1,968,800.00	1,010,000.00	51.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,358,000.00	1,284,200.00	38.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,044,400.00	413,300.00	39.6
210803	Даатгалын үйлчилгээ	158,400.00	158,400.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,000.00	68,000.00	141.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	67,200.00	95,200.00	141.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,850,000.00	389,700.00	21.1
210807	Газрын төлбөр	159,600.00	159,600.00	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	30,400.00	0.00	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,320,900.00	4,733,480.00	0.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,320,900.00	4,733,480.00	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,000,000.00	19,542,284.06	0.0

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	11,634.06	0.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	11,634.06	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,000,000.00	19,530,650.00	97.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,000,000.00	19,530,650.00	97.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	69,292,830.00	0.0
222001	Тоног төхөөрөмж	0.00	69,292,830.00	0.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	925,628,300.00	948,052,348.00	102.4
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	925,628,300.00	948,052,348.00	102.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	12,731,243.94	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	209,949,965.52	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуульд тодорхойлсноор сум, тосгоны эрүүл мэндийн төв хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх зорилготой. Тайлант онд аймгийн ЭМГ, сумын дэвшүүлсэн зорилтын хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж тусгасныг хэрэгжүүлж ажилласан ба Эрүүл мэндийн газрын дарга 95.0, сумын Засаг дарга 96.2 хувийн биелэлтэйгээр дүгнэсэн.

2022 онд ковидын өвчлөл 1, 2, 8 дугаар сард гарсан. Эрт илрүүлэг үзлэг зохион байгуулсан. Хуучин эмнэлэгт их засвар хийгдэж, шинээр УАЗ 31519 маркийн 44,990.0 мянган төгрөгийн 1 машин хандиваар авсан. Дотоод мэдээллийн интернетийн сүлжээнүүдээ шинэчилсэн.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 713,259.3 мянган, орон нутгийн төсвөөс 44,514.0 мянган, нэмэлтээр 190,279.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан. 2021 онд төсвийн санхүүжилтийн дутуу 130,609.8 мянган төгрөгийн авлагатай байсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эрүүл мэндийн төв нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон дараах бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”;
- Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоол “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”;
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол “Автомашин ашиглалтын тухай”;
- Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. ЭМГ болон сумын санхүү албанаас үйл ажиллагаанд хяналт тавьж сар бүрийн 2-ны дотор өр авлага, гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч шаардлагатай асуудлыг шийдвэрлэж, чиглүүлэн ажилладаг байна. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг засаж, зөвлөмжийг биелүүлэн ажилласан тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Санхүүгийн үйл ажиллагаандаа ашигладаг Си Ти Эс програм ашигладаг.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн ба тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 206,224.7 мянган төгрөг буюу 20.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	12,731.2	209,950.0	197,218.8
Авлага	131,184.0	191.5	-130,992.5
Бараа материал	130,094.6	187,247.0	57,152.4
Үндсэн хөрөнгө	722,224.3	805,070.3	82,846.6
Нийт хөрөнгө	996,234.1	1,202,458.8	206,224.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	996,234.1	1,202,458.8	206,224.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	966,234.1	1,202,458.8	206,224.7

Хүснэгт дэх 2022 оны мэдээллийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулж гарсан өөрчлөлтийг судлан үзэхэд өнгөрсөн оны 130,609.8 мянган төгрөгийн санхүүжилтийн авлага, их эмчийн орон дутуу нь цалин урамшуулал, НДШ мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд, 3

төрлийн дансанд 108,582.5 мянган төгрөгийн хандивын бараа, материал авсан нь барааны, шинээр УАЗ 31519 маркийн 44,990.0 мянган төгрөгийн 1 машин хандиваар авсан нь үндсэн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Авлагаа 130,992.5 мянган төгрөгөөр бууруулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 922.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 89.4 сая төгрөг, эрүүл мэндийн сангаас 30.4 мянган төгрөг нийт зарлагыг 1,042.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 489.3 сая, зардлыг 227.2 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр 2022 оны төсвийг 925.6 сая төгрөгөөр эцэслэн баталсан ба төсвийн гүйцэтгэл 81.1 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2022 онд 159,669.2 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан ба төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хишиг-Өнөдөр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төсвийг зохистой удирдаж, зориулалтын дагуу зарцуулах, эд хариуцагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулах талаар болон Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөлүүдийг тусгасан болно.

Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баталгаат тооцоолол аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн аудитор Н.Цэнгэнбаяр, дотоод хяналтыг аудитын менежер Г.Батбаяр гүйцэтгэж, захирал М.Буянбулган хянан удирдаж, аудитын ажлын үе шатны болон гол хяналтуудыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар хэрэгжүүлэв.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд байгууллагын орлогын эх үүсвэр нь улсын төсөв болон үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрддэг тул 2022 оны батлагдсан төсвийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн нийт зардлын 925,628.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,256,3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан дэд дарга, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хангамж, бараа материалын зардал 33,650.6, цалин урамшуулал, НДШ 168,087.3 мянган, шуудан холбоо интернетийн төлбөр 1,715.1 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, төлбөр хураамжийн зардлыг 2,073.8 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2022 онд нийт 144 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 143 мэдээллийг хугацаанд нь байршуулснаас мэдээлээгүй 1, хугацаа болоогүй 2, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн тухай 3 мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроосон 4 мэдээлэл байв. Аудитын баг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журмын 3.2, 3.2.11 заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй гэсэн үндэслэлээр албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аудитын байгууллагын сонгон шалгаруулалтын хугацаанаас хамаарч завсрын аудит хийх боломжгүйд хүргэсэн. Аудитын нээлтийг 2022 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 10 цагаас цахимаар эхлүүлж, аудит хийх мэдэгдэл, аудитад ирүүлэх баримтын мэдээллийн жагсаалтыг цахимаар болон биечлэн хүргүүлж, байгууллагуудын эхний хагас жилийн санхүүгийн тайланд судалгаа хийж, 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт, байгууллагын талаарх мэдээлэлтэй танилцан аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэв.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд хэрэгжилтийг 2022 оны 6 сарын 17-ны өдөр 59 дугаар албан бичгээр зөвлөмжийн биелэлт тус тус Булган аймаг дахь ТАГ-т хүргүүлжээ.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	19,931.8	3	19,931.8	100.0
Зөвлөмж	3	901.7	3	901.7	100.0
Залруулга	4	254,460.0	4	254,460.0	100.0
Нийт дүн	10	275,293.5	10	275,293.5	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн зөвлөмж болон хүргүүлсэн асуудлуудын хэрэгжилт завсрын аудитыг гүйцэхэд анхаарна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар батламж мэдэгдлийн хүрээнд нийт 148,932.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 147,149.4 мянган төгрөгийн алдааг залруулж, эрх зүйн акт зөрчигдсөн² 3 алдаанд төлбөрийн акт, албан шаардлага, дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгөхөөр аудитын баг шийдвэрлэв.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 865.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар Шилэн дансны зөрчилд албан шаардлага өгөв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

5.3 Зөвлөмж

1. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

Илрүүлэлт: Даргын тушаалын гаргаж буй шийдвэрийн үндэслэл, түүнд тавих хяналт сул, нотлох баримтын бүрдэлт дутагдалтай байсан нь эрх зүйн актын шалгуурыг хангахгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д: *Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Даргын тушаалыг эрх зүйн актын шалгуур, шаардлагад нийцүүлэн гаргаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залруулга	1	148,932.4			1	148,932.4	1	148,932.4			1	148,932.4
Дүн	1	148,932.4			1	148,932.4	1	148,932.4			1	148,932.4

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрх зүйн актыг мөрдөөгүй	2	1,783.0	1	865.7	1	917.3						
Дүн	2	1,783.0	1	865.7	1	917.3						